



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 05 сарын 04 өдөр

Дугаар А/82

Мандалговь

“Жирмийн булаг” ХХК-тай гэрээ
байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5 дахь заалт, аймгийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн А/163 тоот захирамжийг үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Гамшгийн эрсдэлийг бууруулах нөөц” ажлын батлагдсан зардлаас Коронавирусын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх зорилгоор хамгаалах хувцас хэрэгсэл хүлээн авах ажлыг “Жирмийн булаг” ХХК-тай 21,745,000 (хорин нэгэн сая долоон зуун дөчин таван мянга) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2. Гэрээнд заасан хугацаанд Коронавирусын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх зорилгоор хамгаалах хувцас хэрэгсэл хүлээлгэж өгөхийг “Жирмийн булаг” ХХК-ны захирал (Н.Батжаргал)-д үүрэг болгосугай.

3. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (А.Нарантуяа), Онцгой байдлын газрын дарга хурандаа (М.Адъяабаатар), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



486210182